

“Бичигт чулуу”-ны манж бичээс

М. Баярсайхан
(МУИС)

Энэ бичээсийн талаар урьд мэдээлэл, судалгааны зүйл нийтлэгдсэн удаагүй. Харин эртний судлалч, доктор Д. Наваан 1969 онд нэрт түүхч Х. Пэрлээ нарын хамт Гурван голын хээрийн шинжилгээний ангиар явахуйд энэ бичээсийг анх олж үзсэн хийгээд ойрмогхон тэр хавийн газраар малтлага судалгааны ажил хийх дашрам мөнөөх бичээстэй хадаа эргэн үзсэнээ бидэнд дурдсан буюу. Чингээд, үүнийг бичигч, МУИС-ийн Монгол Хэл Соёлын Сургуулийн Эх бичиг-Алтай судлалын ангийн оюутны хээрийн дадлагыг хариуцан 2005 оны 6 дугаар сард Хэнтий, Сүхбаатар аймгийн нутгаар явахаар зэхэж байсан тул, уг газрыг очих замынхаа даялалд оруулсан билээ.

Манж бичээс бүхий эл үхэр чулуу Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутагт орших Дэлгэрхаан уулын баруун урдхан, “Булагийн голын ундарга” нэрт газрын ойролцоо бий. Тэнд нутаглагч зарим хүн “Бичигт”, “Бичигт чулуу” гэх зэргээр нэрлэдэг авч бас зарим нь энэ чулууг нэрлэж мэдэхгүй байна. Харин үүнээс хойхно зуу хүрэхгүй метр зайд агч “Бух чулуу”¹-г нутгийнхан андахгүй. Ер нь энэ нутагт үелэн тогтсон боржин чулуу бүхий үхэр чулуу цөөнгүй тул энэ “Бух чулуу”-гаар баримжаалбал, “Бичигт чулуу”-г хялбар олж болно.

1. Манж бичээсийн агуулга

“Бичигт чулуу”-ны урд хана, наран ээвэр газарт чулууны гурван үеэр зааглан нийт дөрвөн хэсэг манж бичээс хар бэхээр бичжээ. Үсгийн тиг, зурлагаас ажихад бийрээр бичсэн нь илэрхий. Бичээс буй чулууны дээд үеийг А, дундахыг В, доод үеийг С үсгээр ялгаад тус бүрийнх нь бичээсийг мөр мөрөөр нь галиглавал,

А-1 бичээс:

1. hūwaliasun tob-i juwan ilaci
2. aniya ninggun biyai
3. juwan ilan amasi
4. [bedere]re čooħa [na]dan
5. biyai orin ninggun de
6. ubade isinjiha.
7. belhetu meyen de

Энэ бичээсийн өндөр 15.5см, өргөн 19см, мөр хоорондын зай 1.5-2.5см. Дөрөвдүгээр мөрийн эхний үгийн дээд хэсэг, мөн мөрийн сүүлчийн үгийн эхний үе балархай байсныг [...] хаалтад бичсэнчлэн сэргээж унших нь зүйтэй мэт. Долдугаар мөр хамгийн тод үзэгдэх атлаа цааш үргэлжлэл байсан гэхээр ул оромгүй юм. Бодвоос, энд өгүүлбэр гүйцээлгүй орхисон байх магадлалтай. Учир нь, энэ эхний бичээсээс хойш хэдэн мөрийн зайд мөн л тасархай хэдэн үг бичжээ. Үүнд,

¹ Бид “Бух чулуу”-наа “Мөнх тэнгэрийн хүчинд их суу залийн игээнээр...” гэж уншмаар XIII-XIV зууны үеийн монгол бичээс, 4 мөр хятад бичээс, төвд мааний үсэг, хоёр гурван дөрвөлжин үсэг байхыг илрүүлсэн бөгөөд цөм хар бэхээр бичсэн нь маш балархай болжээ.

- А-2 бичээс: 1. u[ba]de ...
2. aniya ninggun
3. biyai juwan

Энд бичээсийн ором мэдэгдэвч, үг үсгийг нь тэр гэхийн аргагүй газар (...) тэмдэг тавив.

- В бичээс нь: 1. elhe taifin-i
2. үүsin уyuцi
3. aniya ninggun
4. biyai iče
5. sunja de
6. ubade isinjīha.
7. nayiraltu töb

Өмнөх А-1, А-2 бичээстэй жишин нягталбал бичгийн хэв, дарлага нь өөр хүнийх байж болмоор санагдана. Мөр хоорондын зай 1.5-2.5см, бичээсийн өндөр 10см, өргөн 19см.

- С бичээс нь: 1. ...
2. hūwaliyasun tob-i
3. aniya ...
4. ...
5. ...

Бичээсийг монголчилбол:

- А-1 бичээс: 1. Найралт Төвийн арван гуравдугаар
2. он² зургаан сарын
3. арван гурван хойш
4. [эгэх] цэрэг [долоон]
5. сарын хорин зургаанаа
6. энд хүрч ирвэй.
7. Бэлтгэлт ангид

"Бэлтгэлт анги (*belhetu meyen*)" хэмээх нь хоол хүнс залгуулах зэрэг арын албанаа тушаасан цэргийн анги болно. Э. Хауэрийн манж-герман тольд "*belhetu*" гэдэг үгийг "*Leiter der Zufuhr für das Heer*"³ хэмээн тайлбарлажээ.

- А-2 бичээс: 1. [энд] ...
2. он, зургаан
3. сарын арван

- В бичээс: 1. Энх-Амгалангийн
2. гучин есдүгээр
3. он⁴ зургаан
4. сарын шинийн
5. таванд
6. энд хүрч ирвэй.
7. Найралт Төв

- С бичээс: 1. ...
2. Найралт Төвийн
3. он
4. ...
5. ...

2. Бичээсийн түүхэн хэрэг явдалтай холбогдох нь

Ийнхүү Энх-Амгалангийн 39 дүгээр он болон Найралт Төвийн 13 дугаар онд энд манж цэрэг ирсэн хэмээх эл мэдээг тухайн цаг үеийн түүхэн чухал хэрэг явдалтай холбон сурвалж

² Христийн тооллын 1735 он буюу.

³ Erich Hauer, "Handwörterbuch der Mandschusprache", Weisbaden, 1952, S.86

⁴ Христийн тооллын 1700 он буюу.

бичгүүдээс байцаан үзэж, газар орны байц байдлыг нягталсны үндсэнд зарим зүйлийг тодруулснаа өгүүлсү.

Шэнзү өршөөлт богд хуандийн магад хуулийн зургадугаар дэвтэрт тэмдэглэсэн нь, « Энх-Амгалангийн гучин тавдугаар он (1696), улаан хулгана, зуны дундад сарын шинийн нэгнээ, улаан луу өдөр, Дээр⁵, Түрин (*türing*), Булагийн газраа буувай. Хиа захирагч дотоод сайдад зарлиг буулгасан нь, явган хөтөч, турхан морийг Түрингийн газарт үлдээсүгэй. Үүнд, цзун бин гуань⁶ Бэ Бинь-ийн доорхи ногоон тугийн цэрэг хоёр зуу, Ма Цзинь Лян-гийн доорхи ногдон тугийн цэрэг нэгэн зуу үлдээж, усыг агтлан гуу эрж хэрэм бариад хүрээ байгуулж, Ханхайг үлдээж түүнийг захиргагтун >>⁷ гэжээ.

1696 оны зун Энх-Амгалан хаан гурван замын их цэрэг байгуулан Галдан Бошготыг дайлаар одохдоо дундад замын цэргийг биеэр авч Хэрлэнгийн чиглэлээр давшжээ. Гэтэл Галдан бошгот баруунш буруулан яваад Зуун модны газар Фийангу⁸ жанжны удирдсан манжийн баруун замын цэрэг лүгээ учирч шийдвэрлэх тулаан болсон бөгөөд Энх-Амгалан хаан Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын нутаг Тооно уул хүртэл яваад зам буцсан байна. Ийнхүү дайлаар ирж буцахуй манжийн хаан аль газраа хэдний өдөр буусныг “Магад хууль” болон “Биеэр дайлж өрнө умрын газрыг төвшитгөн тогтоосон бодлогын бичиг” зэрэгт цөм тэмдэглэн үлдээжээ. Тэр дагуу нягтлаад байхад Энх-Амгалан хааны явсан зам яах аргагүй Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутаг, Бүрэнцогтын тосгон (уурхай байсан)-оос Түвшинширээ сумын нутаг руу түрэн орсон “Туран” хэмээх нутаг орчмоор өнгөрсөн байж таарлаа. 1696 оны зуны тэргүүн сарын арван гурванд ирэх зам зуураа хааны бичиж үлдээсэн Сүхбаатар аймгийн Наран сумын нутаг дахь “Сөдөтийн цагаан чулуу”-ны нангиад бичээс ч үүний нэг нуталгаа мөн.

Бүрэнцогтын баруунтайгаас баруун урагш үргэлжилсэн байц хад, хэсэг хэсэг их үхэр чулуу бүхий газрыг нутгийн ард эдүгээ “баруун, зүүн Туран” (буюу Түрин) гэж нэрлэдэг. Түрингийн чулуу нь угтаа бидний дурдсан “Бичигт чулуу”, “Бух чулуу” орчмыг хамран цааш үргэлжилнэ. Энэ Туран бол даруй Энх-Амгалан хааны буудалласан “Түрин” мөн⁹ гэж бодно. Бас дээрх эшлэлд нэр гарсан “Булаг” хэмээх газар нь эдүгээгийн “Бичигт чулуу”-ны дэргэдэх “Булагийн голын ундарга” буй за. “Булаг” гэж тэр усны ундарга бүхий газрын нэрийтгэл байснаа, улмаар тэндээс эх авсан голыг “Булагийн гол”, эхийг нь “Булагийн голын ундарга” гэх болжээ. Эдүгээ “Бичигт чулуу”-наас зүүн хойхно, “Булагийн голын ундарга”-ын хойд талд нэгэн туйр байдаг. Нутгийнхны “Довжоо” гэж нэрлэдэг энэ туйр бол мөн эшлэлд дурдсан “усыг агтлан гуу эрж, хэрэм бариад хүрээ байгуул”-сны үлдэгдэл буюу А-1 бичээсэнд буй “*belhetu meyen*” (бэлтгэл анги)-ийн суурин, цэргийн аму хүнс хадгалдаг газар байсан бололтой.

Цаашилбал, “Магад хууль”, “Биеэр дайлж өрнө умрын газрыг төвшитгөн тогтоосон бодлогын бичиг” зэрэгт Түринтэй холбогдох хэд хэдэн мэдээ буйгаас заримыг дурдвал, манж нар анх Түринд хүрмэгц Галдан бошготод дайталгүй буун өгөхийг тулган элч зарж бичиг хүргүүлсэн байх ба Энх-Амгалан хаан Түринд буудаллаж, тэнд хэрэм хүрээ байгуулан Ханхайг захирагчаар томилсноос гурван өдрийн дараа «...нөхөж хүрүүлэх амууны дотор зургаа, долоон мянган таарыг хурднаа Түринд хүрүүлж бэлд >>¹⁰ хэмээн зарлиг болжээ. Бас Явах цэргийн яаманд зарлиг буулгасан нь, «...таван өртөө суух хүн морийг эрхин түшмэл асан Ханхайгийн дэргэд үлдээ. Өмнө өртөө суулгах түшмэл хүн морийг хэвээр аваачиж суулга... Ханхайгийн дэргэд үлдээсэн таван өртөөг “Таргун Цайдам”-аар хурднаа суулгаж, амуу зөөх тэрэг энэ

⁵ Энх-Амгалан хааныг хэлж буй.

⁶ Монголчилбол бүгд захирагч сайд хэмээх цэргийн түшмэлийн тушаал

⁷ *Дайчин улсын магад хууль*, 13 дугаар эмхтгэл, Хайлар хот, 1990, 273-р талд.

⁸ Монголчилбол, “отгон” гэсэн утгат энэ манж жанжны нэрийг оросын түүхчид хятад сурвалжаас авч Вэй-Янгу гэж бичсэн байдаг. Манай түүхийн утга зохиолд орос ном ашиглахаараа Вэй-Янгу, ахмад манжич нарын гар бичмэл орчуулгыг үзсэн газраа Фиянгу, Фянгу гэх мэтээр хольж хутган бичсэн харагддаг. Иймд, энд уул нэрийг кириллээр галиглан бичлээ.

⁹ Энэ Туран (буюу Түрин) хэмээх газар нь байц ханан хад, үхэр чулуу ихтэй, зарим газраа хүн бүтээсэн гэлтэй тэгш хүрээ хашааны үлдэц шиг өвөрмөц байгалийн тогтоцтой газар тул эртнээс Түрин гэж нэрийдсээр ирсэн бололтой. Монголчуудын “хотын туйр” гэх мэтээр холбон хэлэлцэж, монгол бичгээр “tur-a” гэж бичдэг үг нь манж хэлний “tuga” (багана); жүрчин хэлний “tyr-ga”, ульч хэлний “tuga”, орок хэлний “togo”, нанай хэлний “togo, tora”, орчон хэлний “tū”, солоон хэлний “töbö” (багана, тулгуур), солонгос хэлний “täräk” (цамхаг) зэрэг үгстэй язгуур гарал нэгтэй өвөг Алтай хэлний үг буюу.

¹⁰ *Дайчин улсын магад хууль*, 13 дугаар эмхтгэл, Хайлар хот, 1990, 277-р талд.

өртөөгөөр явтугай >>¹¹ гэжээ. Энх-Амгалан хаан зуны дунд сарын 12-нд Тооно ууланд хүрээд тэр өдрөө Тооно ууланд, 13-ны өдөр Зуун модны газар тус тус Галданг дарсан тухай шүлэглэн гэрэлт бичээс бичиж¹² тэндээс зам эгсэн билээ. Тэнд бас зарлиг болсон нь «хойш эгэхүй цэргийн хүнд Түринд хүрэх таван өдрийн амууг ахуулж, үлсэн амууг өөр өөрийн хошууны сайд биеэр үзэж, нэхэж одох цэргийн хүнд өгтүгэй >>¹³ гэсэн байна. Ийнхүү эгэхдээ 18-ны өдөр Баруун Түрингийн газар, 19-ний өдөр Дундад Түрингийн газар буужээ. Тэр өдөр мөн «Түринд ахуулсан сайд маш цөөн. Гүн Чантай, дэд түшмэл Чаншү, бичгийн дэд түшмэл Сонжо ирж туслан шийтгэсүгэй >>¹⁴ гэжээ. 20-ны өдөр зарлигаар «Их агийг¹⁵ Дундад Түринд сууж хоёр замын их цэргийн амууны зэргийн хэргийг шийтгэ >>¹⁶ хэмээн хоцоргожээ.

Энэ бүхнээс үзэхэд, Түрингийн газар нь Энх-Амгалан хаанаас ихэд анхааран чухалчилж, зам гудас ундны ус, хоол хүнсийг залгуулж, ядарсан цэрэг хөтчийг асрах, агт уналгыг сэлбэх зэрэг албыг хүлээлгэсэн цэргийн өртөөний газар болсон байна.

“Бичигт чулуу”-ны манж бичээс дэх 1700 онд цэрэг ирсэн тухай мэдээ нь хэдийгээр Галдан нас барж, цэрэг нь дарагдсан авч Халхад бэхлэн сахиулж суулгасан манж дарангуй цэрэг¹⁷ мөн үүгээр дайран явдаг байсны баримт юм. Бичээсийн А-1 хэсэгт Найралт Төвийн 13 дугаар он (1735)-ы зургаа, долдугаар сард цэрэг ирснийг тэмдэглэсэн буй. Найралт Төвийн 10 дугаар онд (1732) манжийн хуанди Галданцэрэнгийн Хамид илгээсэн цэргийн эсрэг баруун замын цэргийг, Галданцэрэнгийн өөрийн биеэр Эрдэнэзууг дайлсан гурван түмэн цэргийн эсрэг манжийн хойд замын их цэргийг хөдөлгөсөн билээ. Чингээд 1735 онд дайтахыг түр зогсоон хоёр замын цэргийг хойш татаж суулгасан байна. Цэрэг татахтай холбогдсон зарлиг, айлтгах бичиг “Магад хууль”-д нэлээд буйгаас бидний бичээст хамаарах заримыг эшилье.

«Зуны дундад сар (6 дугаар сар), цагаан бичин өдөр (21-ний өдөр), Цэргийн учир тухайн хэргийг шийтгэгч сайдад зарлиг буулгасан нь, хойд замын цэргийн хүрэнээс улам сулам хойш татсан түшмэл цэргийн дотор Эрдэнэзуугийн газраа байлдахуйд зүтгэсэн ба бас шалгарч шаламгайгаар баатархаж явсан ард нийслэл хотод хурч ирсэн цагт цөм байцааж гаргаад...»¹⁸, «...хойд замын цэргийг анги зохиож зуны сүүл сарын (7-р сар) шинийн гуравнаас эхлэн хоринд хүртэл дараа дараагаар мордуулсугай... заримыг шинэ цэрэг хүрч ирсний хойно илгээсүгэй >>¹⁹ гэжээ. Эндээс үзэхэд, бичээсэнд буй хоёр хугацааны аль аль нь манжийн хойд замын цэргийн ээлж дараагаар хойш эгсэн хугацаатай тохирч байна.

Ийнхүү “Бичигт чулуу”-ны манж бичээс нь агуулгын хувьд ердөө хоёр гурван удаагийн цэрэг ирсэн тухай маш товч үг боловч, тэнд манж цэргийн өртөө, манж цэргийн хэрэм байсныг нотлон, хоёр удаагийн цэргийн хэрэг явдлын гэрч болсноор манж бичгийн төдийгүй түүхийн чухал дурсгал юм.

3. Түрингийн түүх соёлын дурсгалын тухай товчхон

Манж бичээсийн тухай өгүүлэх ялдараа, эндэхийн түүх соёлын дурсгалын талаар товч дурдъя.

Манжийн түүхийн сурвалжуудад Энх-Амгалан хааныг энгэрт нь буусан уулын нэрээр Дэлгэрхаан уулын газар буув гэсэнгүй Түрингийн газар буув гэснийг бид анхаарахгүй байж болохгүй. Энх-Амгалан хаан буцахдаа Баруун Түринд буусны дараа өдөр Дундад Түринд

¹¹ Дайчин улсын магад хууль, 13 дугаар эмхтгэл, Хайлар хот, 1990, 277-р талд, Биеэр дайлж өрнө умрын газрыг төвшитгэн тогтоосон бодлогын бичиг, Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо, 1992, 367-р талд.

¹² Энх-Амгалан хаан Галдан бошготыг дарсантай холбоотой Хайлан голын, Сөдөтийн цагаан чулууны, Тооно уул, Зуун мод, Лан цзюй шань уулын гэсэн нийт 5 нангиад хөшөөний бичиг хоцоргосон нь цөм тэр үеийн “албан ёсны” монгол орчуулгаараа “Магад хууль”-д тэмдэглэгдэн үлджээ. Хожмын судалсан, орчуулсан зүйлсийг, тухайлбал, манай судлаачид Тооно уулын нангиад бичгийг лав зургаан янзаар орчуулан судалсан байдгийг тэр эхтэй тулгаж үзэхэд засаж залруулах зүйл нэг бус буйг энэ ташрамд дурдъя.

¹³ Дайчин улсын магад хууль, 13 дугаар эмхтгэл, Хайлар хот, 1990, 292-р талд.

¹⁴ Дайчин улсын магад хууль, 13 дугаар эмхтгэл, Хайлар хот, 1990, 306-р талд.

¹⁵ Их агь гэдэг нь Энх-Амгалан хааны ахмад хөвгүүн Инь Чжи болой.

¹⁶ Биеэр дайлж өрнө умрын газрыг төвшитгэн тогтоосон бодлогын бичиг, Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо, 1992, 408-р талд.

¹⁷ Хязгаар газрыг ээлжлэн сахиж суух цэрэг.

¹⁸ Дайчин улсын магад хууль, 22 дугаар эмхтгэл, Хайлар хот, 1990, 788-р талд.


¹⁹ Дайчин улсын магад хууль, 22 дугаар эмхтгэл, Хайлар хот, 1990, 847-р талд.

буусныг бодоход тэр хооронд хэдхэн км алслагдахгүй нь лавтай. Тэгэхлээр гурван Түрин гэж байвч, тэдгээрийн хавь орчим газрыг бүхэлд нь хамарсан нутаг орны нэрийг товчдоо "Түрин" л гэдэг байжээ. Энэ хавийн нутагт түүх соёлын дурсгал их бий. Тухайлбал, "Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал" хэмээх лавлахад Дэлгэрхаан уулын дурсгалуудын тухай «Энд шинэ чулуун зэвсэг болон хүрэл, төмрийн үеийн олон арван булш, хадны бичээс, сүг зураг, эртний барилгын турь, олон км үргэлжилсэн чулуун шивээ хороо зэрэг олон төрлийн дурсгалтай. Тухайлбал, Хар тойромын дөрвөлжин булшны цогцолбор, Довжоо хэмээх эртний хотын турь, Энгэрийн бууцны хүннү булш, Цагаан элэгтийн хадны зураг зэрэг нь дорнод монголын бүс нутагт төдийлөн элбэг тохиолддоггүй ховор чухал дурсгал» гэжээ.


Түүнчлэн "Хавцалын адаг"-ийн монгол ба дөрвөлжин бичгийн дурсгал, "Бичигт улаан хад"-ны монгол бичээс, бидний дурдсан "Бичигт чулуу"-ны манж бичээс, "Бух чулуу"-ны бичээсүүд, түүнээс баруунтаа холгүй орших Тэгшийн ланзат хийгээд Харын ланзат, Бичигт зэрэг газрын ланз үсгийн дурсгалууд, Тэмээн чулуу зэрэг газар төвд бичгийн дурсгал байхыг бид оюутны хээрийн дадлагаар явахдаа олж үзсэн билээ. Мөн Бүрэнцогтоос баруунтаа, "Бичигт улаан хад"-ны баруун урдхан "Алтатын хөндий" гэдэг газар нэгэн туйр байх бөгөөд түүнийг XIV үед хамаарах байх гэж судлаачид таамаглаж байна.

Чингийн үе, Энх-Амгалан хааны явсан зам, байгуулсан цэргийн өртөө нь ялангуяа Хаалган хотоос хойш говь тал газрыг туулахад зам гудсын ойр дөт, өвс усны байр байдал зэргийн аль тохиромжтойг харгалзсан байх ёстойгоос гадна, тэр нь нөгөө талаар эртний зам харилцааны зүг чигтэй таарч, ямар нэг байдлаар уламжилсан ч байж болох талтай. Юань улсын Линбэй муж болж байсан Монгол нутгийн зүүн хэсгийг нь захиран засаглах газар Хэрлэн орчмоор төвлөж, Дайдугаас Хэрлэн хүрэх өртөө мөн л үүгээр өнгөрч байсан гэхэд үгүйсгэх аргагүй. Энэ үүднээс авч үзвэл, "Хавцалын адаг"-ийн дөрвөлжин бичээс дэх "Хэрлэнд бүхүүн... заргачин ноёс" гэсэн үгс хийгээд нангиадаар буй дөрвөлжин үсгийн зүйл сонирхол татаж байна.


Ер нь хүрээ хийд, төв суурин, эсхүл зам харилцаа дагасан газарт түүх соёлын дурсгал илүү тохиолддогийг өгүүлэхэд илүүдэхгүй биз ээ. Түрин орчмын түүх соёлын дурсгалыг тал бүрээс нь нарийвчлан судлах нь чухал юм.



"Бичигт чулуу"-ны манж бичигтэй хэсэг



А-1 бичээс (Цахим тооцоолуураар тэнхрүүлсэн байдал)



В бичээс (Цахим тооцоолуураар тэнхрүүлсэн байдал)